



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 02 сарын 03 өдөр

Дугаар А/72

Хэрлэн сум

Үзэсгэлэн худалдаа зохион байгуулж,
хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3 дахь заалт, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын “Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр батлах тухай” 2020 оны 2 дугаар хуралдааны 06 дугаар тогтоол, “Хүнсний хангамж, аюулгүй байдал” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх төлөвлөгөө батлах тухай 2022 оны 16 дугаар хуралдааны 05 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Хүнсний хангамж, аюулгүй байдал үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлэх хүрээнд жил бүр уламжлал болон зохион байгуулагддаг “Цагаан сар-Цагаан идээ 2023”, “Өвлийн идэш-2023” нэгдсэн арга хэмжээг 2023 оны 2 дугаар сарын 10-аас 2023 оны 2 дугаар сарын 11-ний өдрүүдэд Чингис хотод зохион байгуулсугай.

2. Нэгдсэн арга хэмжээг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Ажлын хэсгийн ахлагч:	Э.Мөнх-Эрдэнэ	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Нарийн бичгийн дарга:	Ж.Энх-Амгалан	Хүнс, хөдөө аж ахуйн газрын дарга
Гишүүд:	Г.Ариунчимэг	Хөгжлийн бодлого, төлөвлөлт, хөрөнгө оруулалтын хэлтсийн Хүнс, хөдөө аж ахуйн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Т.Баяржаргал	Аймгийн Засаг даргын Тамгын газрын Аж ахуйн тасгийн дарга
	Г.Нэргүйбаатар	Биеийн тамир, спортын газрын дарга
	Т.Зулбаатар	Соёл, урлагийн газрын дарга

2.

Л.Мэндбаяр	Эрүүл мэндийн газрын дарга
О.Ган-Очир	Аймгийн Цагдаагийн газрын Нийтийн хэв журам хамгаалах тасгийн дарга, Цагдаагийн ахмад
Г.Батгэрэл	“Хэнтий-Ус” ХХК-ийн захирал
С.Болд	Багануур зүүн өмнөд бүсийн цахилгаан түгээх сүлжээ ТӨХК-ийн харьяа Хэнтий аймаг дахь салбарын захирал
М.Шүрэнцэцэг	Хэрлэн сумын Засаг дарга бөгөөд Чингис хотын захирагч
О.Гомбобаатар	“Өндөрхаан хот тохижилт” ОНТҮГ-ын Захирал

3.Нэгдсэн арга хэмжээнд шаардагдах 5,000,000 (таван сая) төгрөгийн зардлыг аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх зардлаас зарцуулахыг Санхүү, төрийн сангийн хэлтсийн дарга (С.Нямдаваа)-д зөвшөөрсүгэй.

4.“Цагаан сар – Цагаан идээ 2023”, “Өвлийн идэш – 2023” нэгдсэн арга хэмжээний удирдамж, бэлтгэл ажлын төлөвлөгөөг гаргаж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Ажлын хэсгийн ахлагч (Э.Мөнх-Эрдэнэ)-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ